


Энэхүү дасгал, даалгаврыг гүйцэтгэхдээ сурах бичгийн агуулгыг унших, теле хичээлээ давтан үзэх, судалж буй агуулгад холбогдох нэмэлт мэдээлэл, эх сурвалж судлах зэргээр мэдлэг, ойлголтоо бататгаарай.

Судлах бүлэг, дэд агуулга



- Дээрх 2 бүлэг сэдэв, 7 дэд агуулгын хүрээнд тулгуур ойлголт тайлбарлах, тохиолдол, эх сурвалж, мэдээлэлтэй ажиллах, жишээгээр тайлбарлах, дүн шинжилгээ хийх, үндэслэл, нотолгоо гаргах, шүүн тунгаах, эргэцүүлэмж, эсээ бичих зэргээр мэдлэг, ойлголтоо бататган чадвар, хандлагаа хөгжүүлэх болно.
- Сурагч та бие даан ажиллах дэвтэртэй ажиллахдаа илүү хариуцлагатай, цагийг үр дүнтэй ашиглан ангийн найз нөхөд, багштайгаа хамтран ажиллах зэргээр өөрийн удирдлагатай бие даан бүтээлчээр суралцаарай.

Түвшин	Блумын таксономийн танин мэдэхүйн үйл
I	Сэргээн санах, ойлгох
II	Хэрэглэх, задлан шинжлэх
III	Үнэлэх, бүтээх



Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

Бүлэг сэдэв/ Анги	10	Д.д	11	Д.д
Нийгэм, нийгмийн харилцаа	10-1-1а.	1, 1.1-1,3, 2, 3, 4 а,б		
	10-1-1б.	1, 1.1-1,3		
	10-1-1в.	1, 1.1-1,3		
	10-1-1г.	1,2,3,4 а,б		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				
Соёл	10-2-1а.	1,2, 2.1-2.4		
	10-2-1б.	1,2, 2.1-2.2		
	10-2-1в.	1, 2, 3		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				

Бүлэг сэдэв/ Анги	10	Д.д	11	Д.д
Нийгэм, нийгмийн харилцаа	10-1-1а.	1, 1.1-1,2, 2, 3, 3.1-3.2		
	10-1-1б.	1, 2		
	10-1-1в.	1, 2,3,4.1-4.3		
	10-1-1г.	1,1.1,1.2		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				
Соёл	10-2-1а.	1, 2		
	10-2-1б.	1,2, 3		
	10-2-1в.	1, 1.1, 1.2		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				

Бүлэг сэдэв/ Анги	10	Д.д	11	Д.д
Нийгэм, нийгмийн харилцаа	10-1-1а.	1.1-1.3		
	10-1-1б.	1.1-1.2		
	10-1-1в.	1,1.1-1.3		
	10-1-1г.	1,2,3		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				
Соёл	10-2-1а.	1		
	10-2-1б.	1,1.1,1.2,2		
	10-2-1в.	1,2		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				

10-1. Нийгэм,  
нийгмийн  
харилцаа

Бүлэг сэдэв:

Сурагчийн овог, нэр: \_\_\_\_\_

Эхэлсэн: Он, сар, өдөр  
Дууссан: Он, сар, өдөр

### 10-1-1а. Хувь хүний үйлдэл ба нийгмийн бүтэц

1. Дараах тулгуур ойлголтуудыг задлан шинжлээрэй.

- |                   |               |
|-------------------|---------------|
| 1. Нийгэм         | 3. Үүрэг      |
| 2. Нийгмийн бүтэц | 4. Байр суурь |


1.1. Ойлголтуудыг тайлбартай нь зөв тохируулан хүснэгтийн хоосон зайд тохирох **үсгийг** бичээрэй.

Нийгэм	Байр суурь	Үүрэг	Харилцан үйлдэл
А.Тухайн байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой, хэм хэмжээлэг шинжтэй зан үйлүүдийн цогц.	Б. Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан, өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдэл юм.	В.Хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс харилцан бие биенийхээ үйлдэлд бэлгэ тэмдгийг ашиглах замаар хариу өгч буй үйл явцыг хэлнэ.	Г.Хувь хүний эдлэх эрх, боломж, гүйцэтгэх үүрэг, бусдын зүгээс хандах хандлагын цогц.

1.2. Дээрх тулгуур ойлголтуудаас хоёрыг сонгон жишээгээр тайлбарлаарай.

1..... 2.....

1.3.Тулгуур ойлголтуудын хоорондын хамаарлыг бүдүүвчээр зураглан харуулаарай.



Энэ QR кодоор нэвтэрч сурах бичгийн 5-7 дахь талыг уншиж судлаад тэмдэглэл хөтлөөрэй.

2. Дараах бодомжуудаас нэгийг сонгон судалсан онолын мэдлэгээ ашиглан тайлбарлан бичээрэй.

- Нийгмийн үүрэг нь хүн бүрт хамаатай тул сурагч миний үүрэг бол суралцах.
- Нэг хүн олон статусыг эзэмшиж болно.
- Би айлын отгон хүү гэдэг нь төрөлх статус мөн.
- Статус ба үүрэг харилцан хамааралтай.



.....

.....

.....


.....

.....

.....

3. Дараах өгөгдлийг уншаад нийгмийн ялгарал, тэгш бус байдал, гажуудал зэрэг ойлголтуудаар тайлбарлаарай.

Хүүхэд бүр үнэ төлбөргүйгээр бүрэн дунд боловсрол эзэмших эрхтэй тул төрийн болон хувийн хэвшлийн сургуулиуд хүүхдийн тоогоор хувьсах зардлын санхүүжилтийг төрөөс авах эрхтэй. Хувийн хэвшлийн сургууль нь сурагч бүрээс сургалтын төлбөр авч байгаа атлаа төрөөс санхүүжилт авах нь шударга уу? Хүүхдээ хувийн хэвшлийн сургуульд сургадаг атлаа татварын хөнгөлөлт эдэлдэггүй нь шударга уу?



Энэ QR кодоор нэвтэрч сурах бичгийн 15-16 дахь талыг уншиж судлаад тэмдэглэл хөтлөөрэй.

4.1. Дараах шүлгийг уншаад *нийгмийн байр суурь, эрх, үүрэг, үүргийн зөрчилдөөн, төрөлх ба олдмол, мастер статусыг* илэрхийлсэн мөр, бадгийг зурж тэмдэглээрэй.

**Мандухай цэцэн хатны тангараг**

Хар цагааны зүсэн ялгагдах үгүй  
 Харь газар бэрлэдэг(бэр болох) билээ, би  
 Хаан чиний үрийг балчир гэж  
 Хасарын үр авъя гэхэд  
 Хайрлан тэтгэх өршөөлийг эрж  
 Хааны ордны дэргэд ирвэй би  
 Харах нүд минь далдирч байна  
 Харайх хөл минь сөгдөж байна...  
 Өргөн их үүдийг чинь хөнгөн гэж  
 Өндөр их босгыг чинь нарийн гэж  
 Өөр хүмүүнд эчвээс(очвоос)  
 Өөд үгүй нэр над хоцормуй...  
 ...Уурга чинь урт биш үү  
 Уургалж ав, өчүүхэн намайг  
 Хуйв чинь агуу биш үү  
 Хурааж ав, өчүүхэн намайг...  
 ...Эзэн Богдоос минь  
 Эрхэм хөвгүүн төрж бөлгөө  
 Эрхэм хөвгүүнийг чинь алдав гэж  
 Эм хүмүүн биеэ мэдэж эчвээс

Үүрдийн тангараг өргөөд  
 Хувь заяаг соёрхож

Хутгийг гуйж залбирсан нь  
 Эзэн хаан таны өмнө  
 Эвдүүлсү би, гэж  
 Үнэн үгсээ өгүүлж  
 Энэ үгийг минь зөвшөөх болбоос  
 Эмэгтэй намайг өршөөх болбоос  
 Эрхэт хаан эцэг минь  
 Эши хатан эх минь  
 Дотоод энгэрт минь  
 Долоон хөвгүүн төрүүл  
 Гадаад энгэрт минь  
 Ганц охин төрүүл  
 Доорд хатан над  
 Долоон нуган заяаваас  
 Долууланд Болд нэр өгч  
 Гал голомтыг чинь сахиулъя  
 Газар нутгийг чинь эзлүүлъя” гэж  
 залбираад харив.

Эх сурвалж: “Мандухай сэцэн хатны домог”. “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив” Ц.Дамдинсүрэн, УБ., 1959, 181-183-р тал.

4.2.Тэмдэглэсэн мөр, бадгийг дараах тулгуур ойлголтоор тайлбарлаарай.

Тулгуур ойлголт	Шүлгийн мөр, бадаг
Нийгмийн байр суурь	
Эрх	
Үүрэг	
Үүргийн зөрчилдөөн	
Төрөлх статус	
Олдмол статус	
Мастер статус	




3. Дараах зохиомжийг уншаад иргэн А,Б,В нарын олдмол статусыг тодорхойлохын тулд ажлын хуудасны зааврын дагуу ажиллаарай.



1974 онд Швейцари улсын Женев хотноо дипломатч В-ийн гэр бүлд төрсөн. 1992 онд бүрэн дунд боловсрол, 1996 онд Оксфордын их сургууль төгссөн. 1998 онд өөрийн компани байгуулсан бөгөөд сарын орлого 500 сая төгрөг. Эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг.



1974 онд Улаанбаатар хотод төрсөн. 1985 онд гэрээсээ дайжсан. Хулгайн гэмт хэрэгт удаа дараалан орж байлаа. Эхнэр, хүүхэдгүй.



1974 онд Налайх дүүрэгт төрсөн. 1982 онд уурхайчнаар төгсөж Налайхын уурхайд 1995 он хүртэл ажиллаж байгаад одоо хувиараа нүүрс олборлодог. 600.000 төгрөгийн сарын орлоготой бөгөөд эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг.

Ажлын хуудас

3.1. Хүснэгтийг нөхөн бичээрэй.

Категори	А	Б	В
Нас			
Хүйс			
Нийгмийн гарал			
Боловсрол			
Ажил эрхлэлт			
Цалин, орлого			

3.2. Дараах асуултын дагуу тэмдэглэл хөтлөөрэй.

1. А,Б, В нарын байр суурьт ямар өөрчлөлт гарсан бэ?
2. А,Б, В нарын олдмол байр суурь, үүрэгт нийгмийн гарал, боловсрол ямар нөлөө үзүүлсэн гэж чи бодож байна вэ?

**Зөвлөмж:** Даалгаврыг хийхдээ Сурах бичгийн 1.1. “Хувь хүний үйлдэл ба нийгмийн бүтэц” сэдвийн 5-26 тал дахь мэдээллийг уншиж ашиглана уу.




1. Зааврын дагуу хийгээрэй.

1.1. Хүн нэгэн зэрэг хэд хэдэн нийгмийн байр суурийг эзэлж байдаг.

Сурагч би нийгэмд ямар, ямар байр суурь эзэлдэг вэ? асуултын хариултыг хүснэгтэд төрөлхийн, олдмол гэж ялган бичээрэй.


Төрөлхийн байр суурь (статус)	Олдмол байр суурь (статус)
<ul style="list-style-type: none"> <li>✓</li> <li>✓</li> <li>✓</li> <li>✓</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓</li> <li>✓</li> <li>✓</li> <li>✓</li> </ul>

1.2. Энэхүү бүдүүвчээр багш, ээж, судлаач, эхнэр хүний нийгэмд эзлэх байр суурь, үүргийг харуулжээ. Эдгээр дүрээс нэгийг сонгон *нэг статус дахь үүрэг харилцаж буй субъектийн байр сууриас хамааран бас олон янз байж болдогыг* дараах бүдүүвчээр илэрхийлээрэй.




Бүдүүвч: Нийгмийн байр суурь, үүргүүд

Өөрийн зурагласан бүдүүвчийг тайлбарын хамт энд хийгээрэй.



1.3. Чиний хувьд 2 жилийн дараа ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд дараагийн шатны сургуульд элсэн суралцах, эсвэл шууд хөдөлмөрийн зах зээл дээр гарч ажиллах гэсэн сонголтууд байгаа. Өөрийн *үрээдүйн* нийгмийн байр суурь, үүргийг тодорхойлон эргэцүүлэмж бичээрэй. *Бичихдээ*, нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн үүрэг зэрэг ойлголтоо ашиглахын хамт хувийн сонголтод тань хувийн биш ямар, ямар хүчин зүйлс (институтийн) хүчин зүйлс нөлөөлж байгааг тодруулаарай.

Дараах QR кодоор нэвтэрч нэгэн сурагчийн бичсэн эргэцүүлэмжийг уншаарай.





1. Дараах зургийг ажиглан тус бүрийн илэрхийлж буй утга санааг бичээрэй.



Эдгээр зургийн өгүүлэмжээр нийгмийн бүтэц, нийгэмшилт, нийгмийн ялгаралтай холбоотой 3-4 нэр томъёоны тайлбар хийгээрэй.

--	--	--

**2. Эх сурвалжтай ажиллаарай.**

“КОВИД-19 цар тахал гарсан нэг жил гаруй хугацаанд хүүхдийн эрхийн бүхий л чиглэлд гарсан ахиц дэвшилд ухралт гарлаа. Өлсгөлөн, хөл хорио, тусгаарлалт, хүчирхийлэл, сэтгэл зүйн хямрал, ядууралд өртсөн, хүчинд автаж хүнтэй гэрлэсэн хүүхдийн тоо нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ тэдний сурч боловсрох, нийгэмших боломж, эрүүл мэнд, хоол тэжээл, хамгаалал зэрэг нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж буурчээ. Цар тахлын үр дагавар хүүхдийн цаашдын ирээдүйд ч арилшгүй ул мөрөө үлдээх нь эргэлзээгүй”

НҮБ-ын Хүүхдийн сангийн гүйцэтгэх захирал Хенриатта Фор

Эх сурвалж: [www.unicef.org](http://www.unicef.org)

**Асуулт даалгавар:**

1. Сурвалжид цар тахлаас үүдэн хүүхдийн ямар эрхүүд зөрчигдөж байна вэ?
2. Цар тахал чамд хэрхэн нөлөөлж байсан бэ? Жишээ баримтаар тайлбарлана уу.
3. Цар тахлын улмаас үүссэн бэрхшээл, үр дагаврыг арилгахад нийгэмшилтийн агентууд ямар үүрэгтэй оролцох боломжтойг хүснэгтийн дагуу бичээрэй.

Агент	Гэр бүл	Сургууль	Үе тэнгийнхэн	Хэвлэл мэдээлэл	Албан байгууллага
Үүссэн бэрхшээл, асуудал					
Арга зам					

1. Зааврын дагуу хийгээрэй.

1.1. А.Маслоугийн хүний хэрэгцээний шатлалыг дарааллын дагуу зөв байрлуулаарай.



1.2. Эдгээр хэрэгцээг нийгэмшилтийн ямар агентууд хангадаг талаар өөрийн нэг өдрийн амьдралын жишээгээр эргэцүүлэмж бичээрэй.



1. Дараах тодорхойлолтыг уншаад хүснэгтийн тулгуур ойлголтуудыг нөхөж бичээрэй.

Нийгмийн хяналтыг албан ба албан бус хэмээн ангилдаг. Албан бус хяналт нь жижиг бүлгийн түвшинд албан бус хэм хэмжээ, хүлээлтийг зөрчсөн үйлдэл хийснийх нь төлөө дургүйцэх, шоолох, нүд үзүүрлэх, үглэх, зэмлэх, шүүмжлэх зэрэг хэлбэрээр илэрдэг хяналт юм. Харин албан ёсны хяналт нь албан ёсны хэм хэмжээг зөрчсөний төлөө сануулга өгөх, ажлаас нь халах, торгох, эрхийг нь хязгаарлах, хорих, цаазаар авах зэрэг албан ёсны үүрэг хүлээсэн байгууллагуудын хүчээр хэрэгждэг, зохих албадлагад тулгуурласан хяналтын тогтолцоо юм.



- Хууль, дүрэм журамд үндэслэгддэг.
- Эрх бүхий байгууллага хэрэгжүүлдэг.
- Албадлага, зохион байгуулалттай байдаг.



- Нийгмийн харилцаа, соёл, зан төлөвт үндэслэдэг.
- Гэр бүл, найз нөхөд, хамт олон зэрэг жижиг бүлгийн орчинд хэрэгждэг.
- Олон төрөл хэлбэртэй.

2. Дараах зураглалыг гажуудлын ямар тулгуур ойлголтоор тайлбарлах вэ?.

**Сонгох үгс:** гажуудлын хэлбэр, урьдчилан сэргийлэх, засан залруулах, шийтгэх, гажуудлын олон янз байдал, сөрөг үр дагавар



3. Дараах хүснэгтийг нөхөж бичээрэй.

Нийгмийн гаж сөрөг үзэгдэл	Энэхүү сөрөг үзэгдэл бий болох шалтгаан	Нийгэмд үзүүлж буй хор хөнөөл	Сэргийлэх (гарах) арга зам



## 10-1-1в. Нийгмийн гажуудал

1. Эх сурвалжтай сайтар танилцаад өгөгдсөн асуултад хариулаарай.

Үйлдвэрийн ажилчин, гал хамгаалагч, үхэрчин Крис Лангены IQ-ийн оноо 195-аас дээш бөгөөд энэ нь ердийн хүнийхээс бараг 100 оноогоор илүү гэсэн үг. Тэр дээд боловсролгүй, өмч хөрөнгө гээд байх юмгүй нэгэн. IQ-ийн ийм өндөр оноотой атлаа тэр яагаад эмч, их сургуулийн багш, инженер болоогүй вэ? Крис нь байнга нүүж явдаг, ядуувтар гэр бүлд төрж өсчээ. Гэр бүлийнхнээс нь хэн нь ч түүний онцгой авъяасыг анзаарч байгаагүй аж. Коллежид суралцах тэтгэлэг авсан байсан ч, ээж нь зохих баримт бичгийг бөглөөгүйн улмаас цуцлагджээ. Коллежид элсээд А сурч байсан Крис өөрийн асуудлыг сургуулийн захиралдаа мэдэгдэж чадаагүйн улмаас F авч улмаар сургуулиас гарахад хүрсэн байна. Өөр мужийн их сургуульд элсэн орсны дараагаар 16 бээрийн газраас сургуульдаа ирэх шаардлагатай болсны улмаас сургуулийн захиргаанаас шаардаж байсан хичээлийн хуваарийг гаргаж чадаагүй тул үргэлжлүүлэн сурч чадсангүй. Тэрээр сэтгэн бодох чадварээр өндөр ч асуудлаа илэрхийлэх, харилцах чадвараар дутмаг байв. Ийнхүү тэрээр их сургуульд сурахаасаа татгалзсан ч өөрийн танин мэдэх сонирхлоо орхигдуулаагүй бөгөөд «Ертөнцийг танин мэдэх онолын загвар» нэртэй бүтээлээ хэвлүүлсэн. Тэрээр өнөөдрийн боловсролын тогтолцоонд шүүмжлэнгүй, эгдүүрхэнгүй ханддаг.

1.1 Крисийг «үйлдвэрийн ажилчин, гал хамгаалагч, үхэрчин» болоход нь институтийн ямар хүчин зүйлс нөлөөлсөн байна вэ?

а. Крисийн хувийн хүчин зүйлс, их сургуулийн дүрэм журам, халамжийн бодлого

**б. Крисийн нийгмийн гарал, их сургуулийн дүрэм журам, халамжийн бодлого**

в. Крисийн харилцааны ур чадвар, нийгмийн гарал, их сургуулийн дүрэм журам

г. Крисийн харилцааны ур чадвар, нийгмийн гарал, их сургуулийн ялгаварлан

гадуурхалт

1.2 Түүний “өнөөдрийн боловсролын тогтолцоонд шүүмжлэнгүй, эгдүүрхэнгүй хандах” болсон гол үндэслэл юу вэ?

а. Түүний онцгой авъяасыг анзаарч байгаагүйд нь

**б. Бэрхшээлтэй суралцагчдад туслах үйлчилгээгүйд нь**

в. IQ өндөртэй суралцагчдаа дэмжиж туслахгүй байгаад нь

г. Эцэг эхтэй нь холбогдон ажилладаггүйд нь

1.3 Кристэй адил оюутан залууст чиглэсэн дараах тусламж дэмжлэг, үйлчилгээнүүдээс аль нь гэр бүлийн хүчин зүйлсийн нөлөөг бууруулж чадна гэж үзэж байна вэ? (Зөвхөн нэгийг сонгоод гол үндэслэлийг эхээс эшлэн эргэцүүлэмж бичээрэй.)

1. Сургалтын тэтгэлэг олгох

2. Харилцааны ур чадварыг хөгжүүлэх агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгах

3. Дотуур байрны дэмжлэг үзүүлэх

4. Амьжиргааны зардлын тэтгэлэг олгох

5. Эерэг хүмүүжлийн аргын сургалтад эцэг эхийг хамруулах

Үндэслэл:



## 10-1-1г. Нийгмийн судалгаа

### 1. Дараах өгөгдлөөс тохирохыг нөхөж бичээрэй

Монгол хэл, бичгийн хичээлийн шалгалтын дэвтэрт “Та гэр бүлийнхээ сарын орлогын дундажийг бичнэ үү?” гэсэн асуулт байсан. Энэ бол ..... судалгаа юм.

*а. Социолгийн судалгаа*

*б. Өрхийн нийгэм, эдийн засгийн байдлын судалгаа*

*в. Сурлагын амжилт болон хүчин зүйлийн хамаарлын судалгаа*

*г. Хөдөлмөр эхрлэлтийн судалгаа*

### 2. Нийгмийн судалгааны аргуудыг тайлбартай нь зөв тохируулан хүснэгтийн хоосон зайд зөв хариуг үсгээр тэмдэглэн бичээрэй.

Асуулга	Контент анализ	Ганцаарчилсан ярилцлага	Бүлгийн ярилцлага
А. Урьдчилан бэлтгэсэн асуулт, хариулт бүхий хуудсаар, судалгааны олон нэгжээс нэг ижил горимоор мэдээлэл цуглуулах арга.	Б. Судалгаанд оролцогчоос асуулт асуух замаар мэдээлэл цуглуулах арга.	В. Баримт бичгээс тодорхой утгын нэгжийг хувьсагчаар сонгон, давтамж, хоорондын хамаарлыг статистик шинжилгээ ашиглан шинжлэх арга.	Г. Тодорхой сэдэв, асуудлыг бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэдээлэл цуглуулах арга.
<b>Б. Арга тус бүр дээр нэг жишээ гаргаарай.</b>			

### 3. Доорх аргуудыг чанарын болон тоон судалгааны аргаар ангилан бичээрэй.

*Бүлгийн ярилцлага, Асуулга, Туршилт, Ажиглалт, Баримт бичгийн чанарын шинжилгээ, Контент анализ, Түүврийн, Анкетын асуулга*



### 4. Судалгааны үе шатыг зөв дэс дараалалд оруулан цэгийн оронд дарааллын тоог бичээрэй.

*/Мэдээлэл цуглуулах ....., сэдэв сонгох ....., загвараа боловсруулах ....., тайлагнах .....,*

*мэдээллээ боловсруулах ....., асуулгаа боловсруулах .....,/*

## 1. Эх сурвалж шинжлээрэй.

**Эх сурвалж 1.** Дэлхийн хоёрдугаар дайны дараа тамхи татах нь олон нийтийн дунд ихээхэн дэлгэрч нийгэмд сайшааж дэмжингүй хандаж байв. 1957 оноос хойш эрдэмтэд тамхи нь олон төрлийн өвчний шатгаан болж байгааг тогтоосон бөгөөд үүнтэй холбоотойгоор энэхүү хорт зуршлын эсрэг давалгаа өрнөх болжээ. Тамхи үйлдвэрлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарынхан, хүрээлэн буй орчныг хамгаалах хөдөлгөөний идэвхтнүүд, засгийн газрын байгууллагууд эрс хурцаар шүүмжилж ирлээ. Тамхи татах гэж буй хүн бусдаас “тамхи татаж болох уу” гэж зөвшөөрөл асуудаг болсон (Эх сурвалж: Н.Смелзер (2001) Социологи”/орч.ред Ү.Нямдорж, 185 дугаар тал). Манай улсад 2012 оноос тамхины хяналтын тухай хууль шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

**Эх сурвалж 2.** Шоронгоос хоёр хоригдол оргожээ. Луйврын хэргээр шийтгэгдсэн 42 настай Рональд Макинтош, банк дээрэмдсэн гэмт этгээд 37 настай Саманте Лопез нарын тухай энд өгүүлж байна. Тэд дурласан хос байсан бөгөөд хэвлэлүүд тэдний орголтын тухай мэдээлсэн даруй тэдний хагацашгүй хоёр гэж нэрлэжээ. Энэ явдал хэрхэн болов? Макинтош нисдэг тэрэг хулгайлжээ. Цэргийн нисгэгч байсан тэр доош зоригтой шумбан орж шоронгийн хашаан дотор бууж Лопезийг авч нисэн оджээ. Шоронгийн хуягууд нисдэг тэргийг буудсангүй, хэрэв буудвал онгоц хашаан дотор унаж олон хүний аминд хүрэх байсан юм. Хосууд цагдаа нараас 10 өдрийн турш нуугдсан ажээ. Олон нийт тэднийг буруутгаж, гэмт хэрэгтэн гэж үзэхээс илүү өмөөрч, хайр сэтгэлийнх нь тухай магтан дуулж байв (Эх сурвалж: Н.Смелзер (2001) Социологи (орч.ред Ү.Нямдорж) 183, 185 дугаар тал).

1.1. Дээрх эх сурвалжуудад нийтлэг ямар асуудлыг хөндсөн байна вэ?. Асуудлын шалтгаан, үр дагаврыг ялган бичээрэй.

.....

.....

.....


.....

.....

.....

.....

1.2. Дээрх эх сурвалжийг контент анализийн аргаар шинжлээрэй.



Энэ QR кодоор нэвтэрч сурах бичгийн 24-р талаас контент анализийн аргын талаар уншаарай.

1. Дараах мэдээллийг уншаад “Нийгмийн бүтэц IQ-ийн түвшинд нөлөөлдөг үү?” сэдвээр эсээ бичээрэй.

1900-аад оноос хүний сэтгэн бодох чадварыг тодорхойлох тестүүдийг ашиглах болжээ. АНУ-д цагаачлан ирсэн англиар ярьдаггүй Итали, Польш зэрэг үндэстнүүдийн IQ-ийн түвшин дундаж түвшин болох 100 онооноос доогуур байв. Мөн хар арьстнуудын дундаж түвшин цагаан арьстнуудынхаас доогуур байлаа. Японд Буракуми хэмээх цөөнх дундаж түвшинээс доогуур үзүүлэлттэй байв. Харин цагаан арьстнуудад үрчлэгдэн өссөн хар арьст хүүхдүүд, АНУ-д цагаачлан очсон Буракумичуудын IQ-ийн түвшин дундаж түвшнээс доогуур биш хэвийн байв. Мөн дундаж давхраанаас дээд давхрааны хар арьстнуудын IQ-ийн түвшин дундажаас доогуур үзүүлэлт үзүүлсэнгүй. Ийнхүү олон социологич нийгмийн статус ба IQ-ийн түвшин хооронд хамаарал байгааг тогтоожээ (Вандер Занден Ж: 96).


1. Бүтцийн дагуу бичих  
2. Ийнхүү олон социологич нийгмийн статус ба IQ-ийн түвшин хооронд хамаарал байгааг тогтоожээ (Вандер Занден Ж: 96). гэсэн гол санааг дэлгэрүүлэн бичих

3. Өөрийн судалсан эх сурвалж, мэдээллийг ишлэн бичих  
4. Агуулгад холбогдох нотолгоо баримттай байх  
5. Бодох эргэцүүлэх, дахин дахин уншиж үзэх, эцэслэн бичих  
6. Үгийн тоо 500-800

2. Зааврын дагуу ажиллаарай.

“Нийгэм судлал X сурах бичгийн 19-20 дах талын судалгааг уншиж, судлаад даалгаврыг хийж гүйцэтгээрэй.

Сурах бичгийг дараах QR кодоор орж уншаарай.




Хаанаас: ..... хот, аймаг  
..... дүүрэг, сум ..... баг  
.... гудамж, байр .....  
тоотгоос илгээв.

1. Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа (түүвэр судалгаа) эх сурвалжийг ашиглан асуудлыг шийдэх арга замыг илэрхийлсэн захидлыг орон нутгийн удирдлага, иргэдэд хандан бичээрэй.

3. Хэвлэл, мэдээллийн эх сурвалжаас нэг асуулга судалгааны материал олж дараах хүснэгтийн дагуу тэмдэглэл хөтлөөрэй.

<i>Судалгааны нэр:</i>	
<i>Эх сурвалж:</i>	
<i>Удиртгал</i>	
<i>Судлаачийн тэмдэглэх хэсэг</i>	
<i>Ерөнхий мэдээллийн хэсэг</i>	
<i>Үндсэн мэдээллийн хэсэг</i>	
<i>Төгсгөл</i>	
<i>Өөрийн дүгнэлтээ энд бичээрэй.</i>	



10-2-2. Соёл

Бүлэг сэдэв:

I

II

III

Сурагчийн овог, нэр: \_\_\_\_\_

Эхэлсэн: Он, сар, өдөр

Дууссан: Он, сар, өдөр

### 10-2-1а. Соёл, соёлыг бүрдүүлэгч элементүүд

1. Соёлын тухай тодорхойлолтуудыг дараах асуултын дагуу харьцуулан шинжлээрэй.

- Соёлын гол шинжид юуг онцлон тодруулж өгснийг тодорхойлолт тус бүрээр тэмдэглээрэй.
- Эдгээр тодорхойлолтын нийтлэг болон ялгаатай талд тулгуурлан соёлыг бүрдүүлэгч хүчин зүйлсийг тоочин бичээрэй.
- Соёлын тухайд хамгийн оновчтой тодорхойлолт таны хувьд аль нь вэ? Сонгосон үндэслэлээ тайлбарлаарай.

Тодорхойлолт	Соёлын гол шинжийг юу гэж үзэв?
<p>“Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаадаг цогц ойлголтыг соёл гэдэг”.</p> <p>Америкийн социологич А.Гидденс</p>	
<p>“Зөгий шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг”.</p> <p>Антропологич Р.Бенедикт</p>	
<p>“Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэл юм”</p> <p>Британы угсаатны зүйч Эдуард Тайлор</p>	
<p>Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн (хэл, бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт) нэгдэл мөн.</p> <p>Германы философич Эрнст Кассирер</p>	
<p>“Соёл гэдэг нь нийгэм болон нийгмийн хэсэг бүлгийн оюун санаа, материаллаг байдал, мэдлэг, оюун сэтгэл санааны шинж байдлын цогц мөн. Соёл нь урлаг утга зохиол төдийгүй амьдралын хэв маяг, хамтын амьдралын арга зам, үнэ цэнэтэй систем, уламжлал, итгэл үнэмшлийг хамаарна”</p> <p>(ЮНЕСКО, 2001)</p>	

Асуулт 2

Асуулт 3

✓  
✓  
✓  
✓

✓  
✓  
✓  
✓

2. Эх сурвалжтай зааврын дагуу ажиллаарай.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын уяачид гол төлөв хэд хэдэн айлууд нийлж, нэг гал болж морио сойх нь элбэг байна. Наадам болохоос ойролцоогоор нэг сар гаруйн өмнөөс уяж, бага багаар уяанд нь дасгаж, хоол тэжээлийг нь багасгаж байгаад богино зайд үсэргэгж эхэлнэ. Ингэхдээ гол төлөв олон жил уясан, их насны морьдоо эхэлж үсэргэдэг байна. Хурдан морь уяхдаа билгийн тооллын нохой өдөр уяж, мориныхоо уяан дээр арц, хүж уугиулан, ариулж, хийморь лундаа сэргээх, аюул барцадаас хамгаалах зорилго бүхий ном хуруулж, тусгай зан үйл хийнэ. Морь сойж байх хугацаандаа тарга хүч ихтэй бол богино зайд ширүүн явдлаар давхиулж, хөлсийг нь авдаг. Ингэж хөлс авах хоёр төрөл байх агаад нэг нь битүү нэмнээгээр хучиж, нөгөө нь задгай буюу нэмнээгүйгээр давхиулж хөлс авдаг. Авах хөлсний хэмжээ их биш бол задгайгаар хөлс авдаг байна. Өөр нэг арга нь усанд шумбуулж, дотроос нь хүйтэн жингээр биеийг нь хөнгөрүүлдэг байна. "...Сар гаруй хугацаанд азарга, соёолон бол гайгүй болчихно. Сойж байгаа морь ханиад хүрвэл манайх бол тогооны угаалтуур хийдэг боролзгоныг усанд хийж буцалгаад, усыг нь шүүж аваад уулгадаг юм. Үндсэндээ хандалж уулгаж байна гэсэн үг. Аль болох өтгөн байвал сайн байдаг юм" гэж уяачид ярьж байна.

*Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дахь Гацууртын орд, түүний орчны бүсэд хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны ажлын тайлангаас. УБ.2015. 39 тал*

2.1. Хурдан морины соёл нь соёлын аль элементээр тайлбарлагдах вэ? Яагаад?

- A. Хэл B. Бэлгэ тэмдэг C. Мэдлэг G. Үнэлэмж D. Хэм хэмжээ
- Яагаад?

.....  
.....  
.....

2.2. Хурдан морь уяхад баримталдаг ямар зан үйлүүдийг энд дурьдсан бэ? Уг зан үйл нь ямар ач холбогдолтой вэ?

.....  
.....  
.....

2.3. Хурдан морины соёлын талаар бид ЯАГААД мэдэх, суралцах, өвлөх, өвлүүлэх, бахархан дээдлэх учиртай вэ?

.....  
.....  
.....

2.4. Хурдан морь унах нь хүүхдийн эрхийн зөрчил мөн үү? Өөрийн санал бодлоо 1-2 нотолгоонд үндэслэн тайлбарлана уу.

.....  
.....  
.....  
.....  
.....

1. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

1. Соёл бол хүний амьдрах арга ухаан, хуримтлуулсан туршлага болж байдаг гэдэг утгаараа ..... мөн.
2. Соёл бол сэтгэлгээний илэрхийлэл, мэдээллийг бүтээгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл болж байдаг утгаараа ..... мөн.
3. Соёл бол юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанар болж байдаг утгаараа ..... мөн.
4. Соёл бол үзэл төсөөлөл, хүсэл зоригоо тэмдэг болгон хувиргаж, нийгмийн туршлагыг дамжуулдаг гэдэг утгаараа ..... мөн.
5. Соёл бол өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил, уламжлалаар дамжуулан хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулж байдаг гэдэг утгаараа ..... мөн.
6. Соёлыг бүтцийг тодорхойлогч үндсэн хүчин зүйлсэд ..... багтана.

**Сонгох үгс:** хэл, мэдлэг, үнэлэмж, хэм хэмжээ, тэмдгийн тогтолцоо

2. Соёлын тухай тодорхойлолтуудыг уншаад дараах 2 даалгаврыг хийгээрэй.

А. Тулгуур ойлголтыг жишээгээр илэрхийлэн бичээрэй.

Б. Тодорхойлолт, эрдэмтний нэрийг тухайн тодорхойлолтыг бичсэн хүрээний өнгөтэй тохируулан хийгээрэй.

Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж, өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг”

Тулгуур ойлголт, жишээ

Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн (хэл, бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт) нэгдэл мөн.

Тулгуур ойлголт, жишээ

Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаадаг цогц ойлголтыг соёл гэдэг”.


Тулгуур ойлголт, жишээ

Германы философич Эрнст Кассирер

Антропологич Р.Бенедикт

Америкийн социологич А.Гидденс

3. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг оновчтой илэрхийлсэн бүдүүвч таны бодлоор аль нь вэ? Сонгосон бүдүүвчээ тайлбарлаарай.




.....

.....

.....



4. Дараах даалгаврыг алхмын дагуу хийгээрэй.



1. Мэдлэгийн төрлүүдийн дутууг гүйцээн бүдүүвчид бичээрэй.
2. Домог, шашин, шинжлэх ухааны мэдлэгийн нийтлэг шинж болон гол ялгаа нь юунд оршиж байна вэ?
3. “Дэлхий нарыг тойрон эргэдэг” гэсэн нотолгоо мэдлэгийн ямар төрөлд багтах вэ? Яагаад?

Домог	Шашин	Шинжлэх ухаан
<p>Хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ мөн. Домгийн үүсэл эртний нийгэмд хамаарх бөгөөд өнөөгийн соёлд ч нөлөөгөө үзүүлсээр байна. Домог нь шинжлэх ухаан, техникийн ололт амжилтад саад тотгор үзүүлдэггүй. Домог бол ямар нэг онолын байгууламж биш, харин мэдрэмж, ид шид, дүр, төсөөлөлд тулгуурласан сэтгэлгээ юм. Эртний хүн домгоор дамжуулан өөрсдийгөө энэ ертөнцийн нэг хэсэг гэсэн баримтыг бий болгож байв. Домгоор дамжин ёс жаяг, зан үйл тогтож хэвшиж, харин эдгээр зан үйл, ёс жаяг нь хорио цээрийн хэм хэмжээ, бэлгэдлийг бий болгож байжээ. Энэ утгаар нь судлаачид домгийг соёлын үндэс</p>	<p>Хүмүүсийн сүсэг бишрэлийн эрэл хэрэгцээгээр бий болсон оюуны соёлын хэлбэр юм. Ертөнцийн хууль зүй, тогтлоос илүү ертөнцийн бурханлаг эхлэл, бурханлаг хүч байдаг гэдэгт итгэх нь шашны гол шинж юм. Шашны байгууллагууд нь шүтэн бишрэгчдийнхээ хэрэгцээг хангаж, үйл ажиллагааг нь зохицуулж байдаг. Шашны байгууллагын хамгийн том хэлбэр нь сүм хийд. Археологийн судалгааны үр дүнгээр шашны сүсэг бишрэлийн энгийн хэлбэрүүдийг 40 мянган жил оршин тогтносон гэж судлаачид тэмдэглэдэг.</p>	<p>Шинжлэх ухаан хэмээх ойлголтын орчин үеийн утга холбогдол нь эртний грект тавигджээ. Шинжлэх ухаан бол үнэн ноттой мэдлэгийг олж авч, эзэмшихэд чиглэгдсэн хүний үйл ажиллагааны чиглэл юм. Мэдлэг бодит байдал, түүний зүй тогтолд таарч тохирох шинж бол мэдлэгийг шинжлэх ухааных гэж хүлээн зөвшөөрөх гол шалгуур мөн гэж ихэнх судлаачид тэмдэглэдэг. Шинжлэх ухаан бол шид домог, сүсэг бишрэлээс ангид үүсч хөгждөг мэдлэгийн тогтолцоо юм. Шинжлэх ухаан бүхэн өөрийн нэр томъёо, багаж хэрэгсэл, туршилтын тоноглол зэргийг ашигладаг. Энэ зорилгын дагуу эрдэм судалгааны</p>



1. Дараах мэдээллийг уншаад соёлын бүрдүүлэгч элементүүдийн уялдаа холбоо, хамаарлыг *Ард Аюушийн хөшөө бол Монголын ард түмний эх оронч байдлын бэлгэдэл юм.* Синквейн бичлэгээр илэрхийлэн бичээрэй. Мөн түүхийн хичээлийн сурах бичгээс Ард Аюушийн талаар дэлгэрүүлэн уншаарай.

### Хүснэгт 2.1. Соёлыг бүрдүүлэгч элементүүд

Соёлыг бүрдүүлэгч элементүүд	Агуулга
Бэлгэ тэмдэг	Соёл бол хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл, соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог гэсэн үг. Бид ярьж, бичиж, зурж, барьж байгуулж байна гэдэг нь үзэл төсөөлөл, хүсэл зоригоо тэмдэг болгон хувиргаж байгаа хэрэг юм. Тэмдэг ил юм уу далд утга илэрхийлдэг. Тэмдгийн илэрхийлж буй далд утгыг бэлгэдэл гэж нэрлэдэг.
Хэл	Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр нь хэл юм. Хэл бол хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл юм. Хүмүүс бодит байдлын тухай мэдээ, мэдээллийг уг мэдээллийг агуулж байгаа юмстай нь заавал шууд харилцах замаар бус, харин тэдгээрийг илэрхийлэн тэмдэглэсэн үг, өгүүлбэр, бичвэр, зураг, дохио зангаа зэрэгтэй харилцах замаар олж мэддэг. Тэгэхээр хэл хэмээх ойлголт нь зөвхөн яриа, бичгийн хэлээр хязгаарлагддаггүй, цэг, таслал, дохио зангаа, хөдөлгөөн ч утга санаа илэрхийлдэг гэсэн үг юм.
Үнэлэмж	Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг үнэлэмж гэдэг. Өөрөөр хэлбэл, хүмүүс амьдралдаа удирдлага болгож буй үзэл санаа, итгэл үнэмшил, үнэт зүйл юм. Жишээ нь, шударга ёс, хүний эрх, эрдэм боловсрол бол аль ч нийгмийн үнэт зүйлс юм. Үнэлэмжүүд нийгэмд хэм хэмжээ, дэг журмыг тогтоох бололцоог олгодог.
Хэм хэмжээ	Хүмүүсийн зан төлөвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэм хэмжээ гэдэг. Хэм хэмжээ нь зохистой сайхан хувцаслахаас эхлээд муу үйл үйлдэж болохгүй гэх хүртэл өргөн хүрээг хамардаг. Хэм хэмжээ нь албан (хууль, дүрэм гэх мэт) ба албан бус (тогтсон заншил, ёс жаяг гэх мэт) байдаг.
Мэдлэг	Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлсийг хэлнэ. Жишээ нь, монголын ард түмэн тэнгэр унших эрдэм, дөрвөн улиралд малаа арчлан маллах, үржүүлэх, бэлчээрийн өвс ургамлын ач тусыг таних зэрэг туршлагын шинжтэй олон зүйл эрдэм ухааныг бий болгожээ. Ийм туршлагын шинжтэй мэдлэгээс гадна шид домог, шашин, урлаг, шинжлэх ухаан, философи гэх мэт мэдлэгийн олон хэлбэр байна. Оюуны соёлын нэг бүрдэл болох урлаг юм.

#### Синквейн бичих дүрэм:

- Эхний мөрөнд 1 нэр үг бичнэ. Энэ нь Синквейний сэдэв байна.
- Хоёр дахь мөрөнд Синквейний агуулгыг илэрхийлэх тэмдэг нэрийн 2 үг байна.
- Гурав дахь мөрөнд Синквейний агуулгад холбогдох үйл явдлыг тодорхойлох 3 үг байна.
- Дөрөв дэхь мөрөнд сурагч сэдвийн талаарх өөрийн байр суурийг өгүүлбэрээр илэрхийлэн бичнэ.
- Тав дахь мөрөнд агуулгыг шинээр өөрөөр тайлбарлан бичнэ.




*Синквейний сэдэв* нь өөрийн сэтгэл хөдлөл, мэдрэмжийг илэрхийлсэн байдаг онцлогтой.

1. Соёлын нэгдмэл шинжийг илэрхийлсэн дараах өгөгдлийг уншаад жишээгээр тайлбарлаарай. *Нийгэм судлал X УБ, 2019* оны сурах бичгийн 39-40 дэхь талаас эх сурвалжтай холбоотой мэдээллийг ашиглана уу.

Аливаа улс орны соёл нь олон талт хэв шинж бүхий хувилбартай байх боловч нэгдмэл шинжийг агуулж байдаг.	
Монгол соёлын хувьд:	Жишээ, тайлбар
Монголчуудын аж төрөх хэв маяг	
Ёс заншил	
Байгаль цаг ууртайгаа зохицон амьдрах арга ухаан	
Монгол дээл бол соёлын нэгдмэл шинжийн илэрхийлэл.	
Би Монгол хүн гэж бахархах сэтгэл.	

2. Монгол соёл бол нэгдмэл шинжтэй” гэсэн нотолгоонд дараах бүдүүвчийг ашиглан жишээгээр тайлбарлаарай.



2.1. Дараах асуултад үндэслэл гарган хариулаарай.



1. Монгол гэр барих ёс нь соёл мөн гэдэгт нотолгоо гаргана уу?
2. Үнэлэмж, хэм хэмжээ хоёрын аль нь анхдагч шинжтэй вэ?



2.2. Үндэсний соёл нь тухайн үндэстнийг нэгтгэхийн хамт бас дэлхийн соёлын олон янз байдлыг бий болгодог гол хүчин зүйл юм гэсэн нотолгоог хэрхэн тайлбарлах вэ?







1. Сурах бичгийн 34 ба 47-р талын тохиолдлыг ажиллаарай.

1.1. Тохиолдолуудад хөндсөн асуудлыг соёл бүлгээр судалсан мэдлэг, ойлголтоо ашиглан 3 минутын илтгэл бэлтгэн танилцуулаарай.  
1.2. Соёлыг хотын ба хөдөө орон нутгийн гэж ангиалахад ямар шалгуур хамгийн чухал вэ? Өөрөө 2-3 шалгуур гарган бусдадаа танилцуулаарай.

1.1. Сурах бичгийн 47-р талын тохиолдолд дурдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхгүй бол цаашид ямар үр дагавар гарч болзошгүй вэ? Өөрийн байр суурийг илэрхийлсэн эргэцүүлэмж бичих гол санаагаа дараах талбарт бичээрэй.

1.2. Хотод амьдрах нь хөдөө амьдрахаас илүү олон боломжийг олгодог. Хөдөө орон нутагт амьдрах нь эрүүл амьдралын үндэс болно гэсэн 2 шийдлээс аль нэгийг сонгон дараах бичиглэлийг хийнэ үү.

Яагаад тухайн шийдлийг сонгов?



Давуу тал, боломж, шийдэх дарааллаар нь эрэмблээрэй.



Эрсдэлийг боломж болгох санаа




2. Зохиолч Б Ренчингийн “Монгол хэл “ шүлгийг дараах холбоос эсвэл QR код ашиглан сонсоод эх хэл, үндэсний соёл, уламжлалаа дээдлэхийн утга учрыг илэрхийлсэн эсээ бичээрэй.

<https://www.youtube.com/watch?v=0Z9cWaUjKIY>



Шүлгийг дараах QR кодоор уншуулаарай.

Эсээ бичихдээ дараах зөвлөмжийг баримтлаарай.



1. **Оршил хэсэг:** Зорилго, яагаад бичих болсон, хэнд зориулсан гэх мэт санааг илэрхийлнэ.

2. **Үндсэн агуулга:** Нэг ба түүнээс дээш догол мөр бүхий дэд хэсгүүдээс бүрдэнэ. Дэд хэсэг бүр нь гол сэдвээ тодосгон нарийсгаж баяжуулна. Өөрөөр хэлбэл, гол асуудлыг тодорхой баримт мэдээлэл, жишээгээр баталж нотлон тайлбарлана. Энэ хэсэг нь зохиогч тухайн сэдвээр хэр зэрэг мэдлэг, хандлагатай байна вэ? гэдгээр илэрхийлэгдэнэ.

3. **Эсээний төгсгөл нь** уншигчдад гол цөм утгыг дахин сануулах ёстой. Зохиогч цэгцэрсэн бодлоо хамгийн сүүлд илэрхийлж байгаагийн гол зорилго бол уншигч тухайн эсээнд дэвшүүлсэн асуудлын талаар үргэлжлүүлэн бодох, уг эсээний утга агуулгыг дахин нэг сэргээн санаж эргэцүүлэхэд нь туслах явдал юм. Эсээ дуусах дөхөж байна гэсэн санаа мэдрэмжийг уншигчдад өгч, гол утга санаануудыг дүгнэн цэгцлэнэ. Мөн ямар эх сурвалж ашигласнаа тусгаж болно. Хэл найруулга гэсэн үзүүлэлтээр тодорхойлогдож болно. (Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагүй, утга төгөлдөр байвал зохино).

Бичсэн эсээгээ дараах шалгуурын дагуу үнэлээрэй.

- Дээрх бүтцийг баримталсан эсэх
- Толгой өгүүлбэрээ нол болгон бичсэн эсэх
- Мэдлэгээ илэрхийлсэн байдал
- Гол санаануудыг тусгасан эсэх
- Эсээний агуулгын талаарх зохиогчийн хамгийн эцсийн бодлыг уншигчдад үлдээсэн эсэх
- Зохиомжийн хувьд харьцуулалт, адилтгал, ёгтлол, хэтрүүлэл зэргийг ашигласан эсэх.
- Нотолгоо болон дэмжлэг гаргаж, гол санаагаа чухал болохыг уншигчдад итгүүлж баримт, жишээгээр нотолсон эсэх
- Зохиогчийн дүгнэлт тодорхой туссан эсэх



1. Соёлыг ангилах өөр ямар шалгуур байж болох вэ? Хүснэгтэд гүйцээн бичээрэй.

Шалгуур үзүүлэлт	Соёлын илрэх хэлбэрүүд
Соёлын суурь үнэлэмжүүд өөр өөр байж болно.	Ёс суртахууны соёл, шашны соёл, дугуй сонирхогдчын соёл гэх мэт
Соёлын бүтээгч, хэрэглэгч нь өөр байж болно.	Олон улсын соёл ба Монголчуудын соёл, баруун монголын соёл
Хүмүүсийн сонголт хийх боломж өөр байж болно	Нэг хэв загварын ба олон хэв загварын соёл гэх мэт
Соёл ямар нэг нийгмийн хэв маягт хамаарна.	Эртний соёл, дундад зууны соёл, орчин үеийн соёл гэх мэт

2. Дараах хүснэгтийг нөхөж бичээрэй. Сурах бичгийн 46-р талын мэдээллийг ашиглана уу.

Соёлын түвшин	Ангилах гол шалгуур	Онцлог	Жишээ
Олон улсын соёл			
Улс үндэстний соёл			


3. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

- а. Соёлыг нэг ба олон хэв загварын соёл гэж ангилахдаа ..... гол шалгуур болгодог.
- б. Би үндэснийхээ соёлын ..... үзүүлэлтүүдээр бахархаж чадна.
- в. Улс үндэсний ба олон улсын соёлын гол ялгаа нь ..... оршино.

1. Дараах түүхийн эх сурвалжийг уншаад соёлын аль ангилалд хамаарахыг тэмдэглэн ямар онцлог шинжээр нь уг ангилалд хамааруулснаа тайлбарлаарай.

**Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутагт орших Үзүүр гялангийн хадны оршуулгын дурсгалууд (X зуун)**

Үзүүр гялангийн хадны хөндийд иж бүрэн хувцастай, 30-40 насны эмэгтэйг морины хамт хутга, эсгий богц, эмээл, хазаар, дөрөө зэрэг морины иж бүрэн хэрэгсэл, ясан сам, хүрэл толь, эсгий цүнх зэрэг эд зүйлс дагалдуулж оршуулсан байв. Эмэгтэйн шарил ба булшны эд зүйлс Алтайн нуруунд далайн түвшнээс дээш 2800 м-ийн өндөрт хуурай сэрүүн нөхцөлд сайтар хадгалагджээ. Гэхдээ тэдгээр олдворуудаас хүмүүсийн анхаарлыг гойд татсан нь хаданд оршуулсан эмэгтэйн гутал байлаа. Эмэгтэй 1000 гаруй жилийн өмнө амьдарч байсан боловч түүний гутал орчин үеийн “Адидас” брэндийн спорт гуталтай тун төстэй харагджээ. Үүнээс үүдэн олон улсын хэвлэл мэдээллээр уг эмэгтэйг “Адидастай эмэгтэй” гэж нэрлэв. Булш тоногдоогүй, бүрэн бүтнээрээ олдсон нь хамгийн чухал байв. (Эх сурвалж: Монголын түүх X, хуудас 6, 2019 он)



**1.1.** Дараах асуултын дагуу эргэцүүлэн бодож эсээ бичихдээ ашиглаарай.

- Чиний хувьд уг эх сурвалжийн хамгийн гол үнэ цэнтэй санаа юу байна вэ?
- “Булш тоногдоогүй, бүрэн бүтнээрээ олдсон нь хамгийн чухал байв.” гэсэн өгүүлбэрийг дэлгэрүүлэн тайлбарлаарай.
- Соёлын өвийг хамгаалах, өвлөх арга хэлбэрүүдийн талаар чи юу мэдэх вэ? Яагаад хамгаалах, өвлөхийн чухлыг 2-3 үндэслэл гарган тайлбарлаарай.

**1.2.** Түүхийн хичээлийн мэдлэг, ойлголтоо ашиглан дээрх эх сурвалжийг дэлгэрүүлэн судалж дараах даалгавраас нэгийг сонгон үйл ажиллагааны удирдамж боловсруулаарай.  
*Тодруулга:* Орон нутгийнхаа түүх, соёлтой холбоотой өөр эх сурвалж судалж энэ зааврын дагуу ажиллаж болно.

*Боловсруулсан удирдамжаа ангийнхандаа санал болгон нэг үйл ажиллагааг багаар хамтран хийгээрэй.*

- АХА тэмцээний асуулт зохиох,
- Эсээ бичих сэдвийн жагсаалт гаргах,
- Мэтгэлцээний шийдлүүд боловсруулах,
- Энэхүү эх сурвалжийг сурталчилсан ханын сонин, постер бэлтгэх гэх мэт



1. “Би Монголын түүх, соёлоор бахархдаг” сэдэвт **Постер** илтгэл бэлтгээрэй. Дараах алхмын дагуу хийнэ үү!



Соёлын үнэт зүйлсийн жагсаалт гаргаарай.

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.

Соёлын үнэт зүйлсийнхээ өвөрмөц шинжийг тайлбарлан бичээрэй.

Постер илтгэлдээ уг соёлын өв ямар түүхийг өгүүлдэг, яагаад хайрлан хамгаалах, бахархах ёстой талаар мэдээлэл оруулаарай.

Тайлбар:

Тайлбар:

Blank box for notes.

Тайлбар:

Соёлын дурсгалт газруудын байршлын зураглал хийгээрэй.

Зураглал:

Сургуулийнхаа сурагчд, орон нутгийн иргэдэд зориулж соёлын өвийг хэрхэн хайрлан хамгаалж болох талаар зөвлөмж эсвэл уриалга бэлтгэн постертоо оруулаарай. Өмнөх даалгавраар бичсэн эсээгээ ашиглаарай.

Blank box for notes.



Постер бэлтгэх арга зүйн мэдээллийг дараах QR кодоор уншуулан судлаарай.

Бүлэг сэдвийн хичээлээ судалж дууссаны дараа багшийн удирдлага дор дараах даалгаврыг ангиараа хамтран хийнэ.



### Танхимын бус сургалтаар хээрийн судалгаа хийх аргачлал

1. Хичээлийн 20 минутад хээрийн судалгаа хийх ажлын удирдамжтай танилцана.
2. Үлдсэн 20 минутад багаар ажиллах ажил үүргийн хуваарь гаргана.
3. Багшаас асуух, тодруулах зүйл байвал асууна.

**Хээрийн судалгааны зорилго:** Орон нутгийнхаа тусгай хамгаалалттай газар нутагт дахь соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтыг хээрийн судалгааны аргаар судалж, эрсдэлийн хүчин зүйлийн төвшинг тогтоон үнэлэх, нийтлэл бичих санаа цуглуулах

#### Алхам 1: Судалгаа эхлэхийн өмнө

- Орон нутгийнхаа соёлын өвийг судлах /“Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” /аймгийнхаа/ ном, гарын авлага, түүхийн хичээл/
- Хээрийн судалгаа хийх газар, судлах соёлын өвийг сонгох
- Ажлын хуудас 1-ийн үзүүлэлтүүдийн дагуу тэмдэглэл хийх заавартай танилцах, ойлгомжгүй зүйлээ асууж тодруулах
- Баг дотроо ажил үүргийн хуваарь гаргах
- Хэрэглэх зүйлсийн жагсаалт гаргах, бэлтгэх

#### Алхам 2: Судалгааны үед

- Ажлын хуудас 1-ийн үзүүлэлтийн дагуу соёлын өвийг судлан тэмдэглэх
- Судалж буй соёлын өвийн зураг авах

#### Алхам 3: Судалгааны дараа

- Баг бүр өөрсдийн судалж буй соёлын өвийн одоогийн нөхцөл байдалд дараах аргачлалын дагуу орон нутгийнхаа байгаль орчны байцаагч, болон мэргэжлийн хүмүүстэй хамтран үнэлгээ хийх.
- Судалгааны үр дүнгээр товч тэмдэглэл- нийтлэлийн эхний санааг боловсруулах.

#### Алхам 4: Хээрийн судалгааны тэмдэглэлдээ тулгуурлан нийтлэл бичих

- Нийтлэл бичих зааврын дагуу ажиллах
- Бичсэн нийтлэлээ хянуулах, засварлах
- Нийтлэлээ эцэслэн бусдад түгээх



## Хээрийн судалгааны тэмдэглэл хөтлөх хуудас

### А. Ерөнхий мэдээлэл

.....оны .....сарын ....өдөр .....цаг

Бид ..... суурингаас ..... чиглэлд .....,  
 ..... сумдын нутгаар дайран ..... аймгийн .....  
 сумын нутагт .....хүрэлцэн ирлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн соёлын өвийн ерөнхий мэдээлэл.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

### Б. Гэмтсэн соёлын өвийн эрсдлийн хүчин зүйлсийг ажиглан тэмдэглээрэй.

Байгалийн хүчин зүйл	Нийгмийн хүчин зүйл

В. Тэмдэглэлд үндэслэн тухайн соёлын өвийг сэргээн засварлахад ямар боломж, байгаа, түүнд та бүхэн хэрхэн оролцох талаар товч тэмдэглээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

### Хэрэглэгдэхүүн:

- Байгаль орчны мэдээллийн сан <https://eic.mn/>
- Хээрийн судалгаа хийх аргачлал
- Тэмдэглэл хөтлөх хуудас
- Нийтлэл бичих арга зүйн мэдээлэл
- Ажлын хуудас 1 ба 2

**Үнэлгээ:** Даалгавраа багшдаа болон багийн гишүүддээ хянуулаарай.

## Ажлын хуудас 2

Бичсэн нийтлэлдээ дараах шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийгээрэй. Үнэлгээнд тулгуурлан засан сайжруулаарай.

Д.д	Шалгуур	Тэмдэглэгээ хийх
1.	Нийтлэл бичих санаа буюу асуудлыг судалсан арга тодорхой байх	
2.	Тусгай хамгаалалттай газар нутагт байдаг соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаар иргэд, олон нийтийн анхаарлыг хандуулахыг зорьсон гол санаа, шийдлийг тусгасан эсэх	
3.	Хэн? Юуг? Хаана? Яагаад? Хэзээ? Яаж? зэрэг асуултад хариулагдахаар эхлэл, өрнөл, төгсгөл тодорхой	
4.	Асуудлыг түүх нийгэм, улс төр, эдийн засаг, байгаль орчны талаас судалсан эсэх	
5.	Нотлох баримтууд /фото зураг, сэтгэгдэл, судалгааны материал зэргийг/ хавсаргасан эсэх	

## ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

**Загвар 1. Аргачлал:** Асуулт бүрийг уншиж, тохирох түвшинд (✓) зөвлөж, тэмдэглэнэ. Арын тэмдэглэл хэсэгт нь ямар хугацаанд хэрхэн нөхөн гүйцээх, өөрөө болон найз нөхөд, багшаасаа авах дэмжлэг, тусламж зэргийг бичиж тэмдэглэх бөгөөд энэхүү мэдээллийг өөрийн сурах үйлийн төлөвлөлт боловсруулахад ашиглах юм.

Даалгавар	Тулгуур асуултууд	Сайн Мэднэ	Дунд зэрэг	Мэдэхгүй байна.	Тэмдэглэл

### Загвар 2.

1. *Улаан гэрэл*- Уншиж , сонсож, ажиглаж, хэлэлцүүлэгт оролцож байхад юу чамайг зогсоож, үнэн зөв гэдэгт эргэлзүүлсэн бэ?

.....  
.....  
.....

2. *Шар гэрэл*- Үнэн зөв эсэхэд эргэлзэхэд хүргэсэн, уншиж , сонсож, ажиглаж, хэлэлцүүлэгт оролцохдоо бага зэрэг эргэлзсэн зүйл байна уу?

.....  
.....  
.....





3. *Ногоон гэрэл*- Шууд ойлгосон хичээлийн агуулга юу байв?

.....  
.....  
.....

**Загвар 3.** 3-2-1 аргын тайлбар: Гурван чухал үг, тулгуур ойлголт, агуулга байна. Хоёр асуулт, бусдад хэлэх, тусган хэрэгжүүлэх нэг санаа бичнэ.



**Загвар 4. ДАВХАР ТОЙРГООР ЯРИЛЦАХ:** Ангийнхантайгаа ярилцаж мэдлэг, ойлголтоо бататгах арга. Сурагчид нэг, хоёроор тоолон давхар тойргоор сууна. Дотор талын тойрогт суусан сурагчид дасгал, даалгавар хийхдээ сурч мэдсэн, дараагийн даалгавар хийхэд анхаарах зүйлийн талаар гадна талын тойргийн найзууддаа ярьж өгнө. Дараагийн ээлжинд үүргээ солилцон ярилцлагыг үргэлжлүүлнэ.

### Загвар 5

 Би хийж дууссан	 Би эргэлзэж байна	 Надад тусламж хэрэгтэй байна	 Багшийн үнэлгээ

## ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

**Загвар 6.а** Аргачлал: Өөрийн хийсэн дасгал, даалгаврын гүйцэтгэлийг дараах бүдүүчээр үнэлэн тэмдэглээрэй. /Будах, хийсэн даалгаврын дугаараа бичих, дахин хийх эсэх/



## ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

**Даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээний рубрик:** Даалгавар гүйцэтгэсний дараа сурагч бүр дараах рубрикээр өөрийгөө үнэлнэ.

№	Илрүүлэх шалгуур үзүүлэлт	Түвшин		
		Надад дэмжлэг шаардлагатай байна 0-1 оноо	Нэмж судлах шаардлагатай байна 2-3 оноо	Би хангалттай сайн ойлгосон 4-5 оноо
<b>Шалгуур 1. Мэдлэг, ойлголт эзэмшилт</b>				
1	.....бүлгийн агуулгын хүрээнд мэдэж, ойлгох эргэцүүлэх	1 хэсгийг зөв бөглөсөн Тохирох жишээ дурьдаж тайлбарлаагүй	2-3 хэсгийг зөв бөглөсөн Тохирох жишээ авсан боловч, үндэслэгээ тайлбар дутмаг, ойлголт муутай	Бүгд зөв бөглөсөн Мэдлэг, ойлголт сайн.Тодорхой жишээ баримт дурьдаж зөв тайлбарласан
<b>Шалгуур 2. Баримт, мэдээлэлтэй ажиллах чадвар</b>				
1	Мэдээллийн утгыг ойлгож гол давуу талыг гаргах	Утгыг ойлгоогүй баримт мэдээллээс шууд хуулж бичсэн	давуу талуудыг бүрэн гүйцэд дурьдаагүй	....үр дүнд хүрэх гэх мэт давуу талыг оновчтой гаргасан
2	Нөхцөл, шалтгааныг тодорхойлох	Ялгаанд нөлөөлж буй шалтгааныг дурдаж бүрэн гүйцэд тодорхойлж бичээгүй.	Ялгаанд нөлөөлж буй шалтгааныг зарим шалгуураар дутуу тодорхойлсон	Ялгаанд нөлөөлж буй шалтгааныг шалгуураар гүйцэд тодорхойлсон
3	Бодлогын чиглэл, үйл ажиллагааны уялдаа хамаарлыг илрүүлж, ач холбогдлыг дүгнэх	Ач холбогдлыг илрүүлж, дүгнэж чадаагүй, өөрийн улсын үйл ажиллагаатай холбоотой бус	Ач холбогдлыг уялдаа холбоотой тайлбарласан боловч жишээ баримтаар дутуу дүгнэсэн	Бодлогын гол чиглэл, үйл ажиллагааны хамаарлыг харуулж ач холбогдлыг жишээгээр бүрэн үнэлж дүгнэсэн
<b>Шалгуур 3. Статистик мэдээлэлд үндэслэн, тайлбарлах, дүгнэх чадвар</b>				
1	Асуултын дагуу хэрэгцээт тоон мэдээллийг графикаас олж, нийтлэг шинжийг тодорхойлж, тайлбарлах	Тоон мэдээллийг дутуу ойлгосон, шинжийг нэрлэсэн боловч оновчтой биш, шалтгааныг бүрэн тайлбарлаагүй	Нийтлэг шинжийг олж харсан боловч оновчтой тайлбарлаж чадаагүй	Асуултын дагуу хэрэгцээт тоон мэдээллийг графикаас олж, нийтлэг шинжийг бүрэн тодорхойлсон
2	Асуудлыг шийдэх боломжит хувилбар дэвшүүлж үндэслэлийг тайлбарлах	Ямар нэг арга зам хувилбар дэвшүүлээгүй	1-2 арга зам бичсэн ч мэдээлэлдээ жишээ татаагүй, үндэслэл хангалтгүй	Хэд хэдэн хувилбар байж болохыг жагсаан бичсэн, чухлаас чухал бус руу нь эрэмбэлсэн, үндэслэлийг тайлбарласан
3	Сул талыг онолын үндэслэлтэй дүгнэсэн	Аль нэг онолын үндэслэл гаргаж дүгнээгүй	Онолыг дурьдсан боловч үндэслэлийг гаргаж чадаагүй	Сул талыг ...онолыг үндэслэн зөв дүгнэсэн